



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/128

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны "Сумын 2021 оны төсөв батлах тухай" 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Сумын төвийн камержуулалт"-д зарцуулагдах 15972110 (арван таван сая есөн зуун далан хоёр мянга нэг зуун арав) төгрөгийг зарцуулсугай.

2. Сумын төвийн камержуулалтын ажилд зарцуулагдах 15972110 (арван таван сая есөн зуун далан хоёр мянга нэг зуун арав) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ